



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 344

Улаанбаатар хот

Компанийн эзэмшигчдийн өмч дэх  
төрийн өмчийн дүн, дүрэмд өөрчлөлт  
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, бусад хөрөнгийн эх үүсвэрээр 2016-2017 онд хийгдсэн нийт 43,068,066,084.00 (дөчин гурван тэрбум жаран найман сая жаран зургаан мянга наян дөрөв) төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийн дүнгээр “Алтай-Улиастай эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. “Алтай-Улиастай эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 5.1 дэх заалтанд “Компани нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 173,199,710 (нэг зуун далан гурван сая нэг зуун ерэн есөн мянга долоон зуун арав) ширхэг хувьцаатай” гэснийг “Компани нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 603,880,372 (зургаан зуун гурван сая найман зуун наян мянга гурван зуун далан хоёр) ширхэг хувьцаатай” гэж өөрчилсүгэй.

3. “Алтай-Улиастай эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг компанийн гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэнд үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлого, төлөвлөлт удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА